



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 4/33

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Засаг даргын Тамгын газарт шатах, тослох материал нийлүүлэх” тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Гэрэлт-Од - Ерөнхий боловсролын сургуулийн багш


Нарийн бичгийн дарга: Б.Эрдэнэжаргал - Ерөнхий боловсролын сургуулийн багш

Гишүүд: Э.Нямдорж - Ерөнхий боловсролын сургуулийн багш
Д.Чанцал - 2 дугаар Цэцэрлэгийн нярав
Т.Даваадорж - Иргэний төлөөлөл (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (С.Гэрэлт-Од)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж байгууллагын Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ